



БОДЛОГЫН ТОЙМ

№. 04.2018



GERMAN-MONGOLYN ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
"ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ" ТӨСӨЛ

Хураангуй

- Монголын газар тариаланд ургамал хамгааллын бодис/УХБ/ ашиглах нь харьцангуй бага боловч хэрэглэх шаардлага улам бүр нэмэгдэж байна;
- УХБ-ын импорт, худалдааг төрөөс зохицуулж, хянадаг;
- Зөвшөөрөгдөөгүй УХБ-ыг зах зээлд хууль бусаар худалдаалж байна;
- Газар тариалангийн үйлдвэрлэлд зохистой дадал болон ургамал хамгааллын цогц арга хэмжээний талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байна;
- Энэ сэдвээр ААН-үүд болон холбогдох мэргэжлийн байгууллагуудад мэдээлэл, сургалтын хэрэгцээ их байна;
- УХБ болон ургамал дахь түүний үлдэгдэлд шинжилгээ хийх улсын лабораториудын тоног төхөөрөмжийг сайжруулах, мэргэжилтнүүдийг чадавхижуулах шаардлагатай байна.

Тойм бэлтгэсэн

Др. Альфред Катер
Герман-Монголын хамтын ажиллагааны
"Тогтвортой хөдөө аж ахуй" төслийн
удирдагч

a.kather@iakleipzig.de

Монгол орны газар тариалангийн салбар дахь "Ургамал хамгааллын зохистой дадал"

Монгол улс 2017 онд нийт 552,000 га талбайд тариалалт хийсэн бөгөөд голлох таримал болох үр тарианы тариаланг 500-10,000 га хүртэлх талбайтай аж ахуйн нэгжүүд, харин төмс, хүнсний ногооны тариаланг голчлон 0,5-50 га талбайтай өрхийн аж ахуйнууд эрхэлж байна. Тариаланд ихэвчлэн уринш - үр тариа (буюу тосны ургамал) гэсэн сэлгээг мөрдөж буй нь талбайг уриншлах замаар хөрсний чийг, шим тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, хог ургамлын тархалтыг бууруулах зорилготой. Уриншийг цулгүй ба химийн уринш гэж ангилах бөгөөд цулгүй уриншинд хог ургамалтай тэмцэхэд ургалтын үед нь хэд хэдэн удаа хөрс боловсруулалт хийж, харин химийн уриншинд хөрс боловсруулалт болон глифосат гербицид цацах аргыг хослуулан хэрэглэж байна.

Ургамал хамгааллын бодисын хэрэглээ

Өнөөгийн байдлаар Монгол улсад 78 төрлийн үйлчлэх бодисын агууламжтай УХБ-уудыг ашиглахыг зөвшөөрсөн. Хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй гербицид болох глифосатыг химийн уриншинд хог ургамалтай тэмцэхэд, мөн үр тариа, төмс, рапсын болц түргэсгэх (хагдруулах) зориулалтаар ашиглаж байна. УХБ-ын импортын хэмжээ сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд эрчимтэй өсчээ /1-р зураг/.



Зураг 1. Ургамал хамгааллын бодисын импорт /мян. ам.доллар/

Эх сурвалж: НҮБ-ын ХХААБ

УХБ-ын худалдаа эрхлэгчид болон тариалангийн томоохон аж ахуйнууд гербицидээс гадна төрөл бүрийн инсектицид, фунгицид, родентицид импортлож байна. Фунгицидыг голчлон үр ариутгалд, родентицидыг мэрэгчтэй тэмцэх зорилгоор тариаланд болон бэлчээрт ашигладаг. УХБ-ын ихэнхийг ОХУ болон БНХАУ-аас оруулдаг.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) жил бүр нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж тухайн жилд төлөвлөгдсөн УХБ-ыг Тариалан Эрхлэлтийг Дэмжих Сан (ТЭДС)-д төвлөрүүлдэг бөгөөд тус сангаас тариаланчдад 30 хувийн урьдчилгаа төлбөртэй, үлдэгдлийг ургац хураасны дараа буюу санд тушаах буудайгаар тооцох хөнгөлөлттэй нөхцлөөр тариаланчдад борлуулдаг. ТЭДС нь ийнхүү УХБ-ын нийлүүлэлтэд хамгийн гол үүргийг гүйцэтгэж байна.

Мэргэжлийн байгууллагууд болон орон нутгийн агрономчид, мэргэжлийн хяналтын байцаагчдаас авсан мэдээллээс үзэхэд төрийн хяналт дор зохих хууль, журмын дагуу хийгддэг УХБ-ын импортоос гадна хувь хүмүүс хараа хяналтаас гадуур төрөл бүрийн УХБ хилээр оруулж ирэх тохиолдол нилээд гардаг бөгөөд уг бодисуудыг голчлон төмс, хүнсний ногооны тариаланд хэрэглэдэг байна. Хууль бусаар импортлосон УХБ-ын найрлага, хэрэглэх заавар ихэвчлэн монгол хэлээр орчуулагдаагүй байх тул тариаланчид зөвхөн худалдаалж буй хүнээс буюу өмнө нь хэрэглэж үзсэн гэх тариаланчдаас авсан мэдээлэлд үндэслэн худалдаж авч, хэрэглэдэг. Ийнхүү зориулалт, норм, хугацаа болон аюулгүй ажиллагааны дүрмийнх нь талаар баталгаатай мэдээлэлгүйгээр УХБ ашиглаж буй нь төмс, хүнсний ногооны тариаланд томоохон эрсдэл үүсгэж байна. Зохих хууль, журмын дагуу нийлүүлэгдэж буй УХБ-уудын хувьд хэрэглэх заавар, хадгалах нөхцөл зэрэг холбогдох бүх мэдээллийг монгол хэлээр сав, баглаа боодол дээр нь байрлуулах буюу эсвэл танилцуулга хэлбэрээр тухайн УХБ-ыг дагалдуулан өгдөг.

Газар тариаланд хамгийн өргөн хэрэглэгддэг УХБ болох глифосатын үйлчилгээ сул байгаа талаар тариаланчид гомдол их гаргадаг. Гэвч энэ нь тухайн УХБ-ын чанар муугаас (тухайлбал хямд үнэтэй, үйлчлэх бодисын найрлага багатай УХБ ашигласнаас) буюу эсвэл ашиглалтын технологийн алдаанаас шалтгаалж буй эсэх нь тодорхойгүй. УХБ-ын чанарыг шинжлэх, хянахад мэргэжлийн лаборатори дутагдаж байна.

УХБ-ыг талбайд цацахад үр тарианы аж ахуйнууд зориулалтын техник ашигладаг бол хүнсний ногооны тариаланд автомаксыг голчлон ашиглаж байна. УХБ шүршигч техникийн бүрэн бүтэн байдалд улсаас хяналт тавьдаггүй, олон аж ахуйн нэгжүүдийн техник нь элэгдэж хуучирсан байдалтай байна. Харин томоохон аж ахуйн нэгжүүд орчин үеийн, хүчин чадал сайтай чиргүүлийн болон өөрөө явагч хор цацагчийг ашиглаж байна /Зураг 2-3/.



Зураг 2. Өөрөө явагч УХБ шүршигч



Зураг 3. Сургалтын үеэр, Хэнтий аймаг, 2017.06 сар

УХБ-ын хэрэглээний өнөөгийн байдлаас дүгнэхэд цаашид тариаланчдад ургамал хамгааллын зохистой дадлыг хэвшүүлэх чиглэлээр мэргэжлийн сургалт, зөвлөгөө өгөх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний ажил

Газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний тэргүүлэх байгууллагуудад Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС)-ийн Агроэкологийн сургууль болон Улаанбаатар хот дахь Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн (УХЭШХ), Дархан хот дахь Ургамал Газар Тариалангийн Хүрээлэн (УГТХ) багтана. Агроэкологийн сургууль нь сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг хослуулж, харин ЭШ хүрээлэнгүүд хэрэглээний судалгааны чиглэлээр түлхүү ажиллаж байна. УХЭШХ нь анх 1958 онд Ургамлын хорио хамгаалалтыг эрхлэн байцаах анги нэртэйгээр байгуулагдаж байсан бол 1992 оноос одоогийн нэр, бүтэц, зохион байгуулалтад орж, ургамлын эмгэг судлал, шавьж судлал, хог ургамал, биотехнологийн чиглэлээр түршилт, судалгаа, сургалтын үйл ажиллагааг эрхэлж байна. Тус хүрээлэн нь олон улсын түвшинд их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, УХБ үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй, дотоодод төрийн (ХХААХҮЯ, МХЕГ), хувийн хэвшлийн (УХБ импортлогчид), төрийн бус болон олон улсын донор байгууллагууд (Тогтвортой хөдөө аж ахуй төсөл, НҮБ-ын Хүнс, ХАА-н Байгууллага, Швейцарын Хөгжлийн Агентлаг зэрэг)-тай хамтран ажилладаг. Түүнчлэн Монгол улсад шинээр зөвшөөрөгдөх УХБ-ыг УХЭШХ-ийн талбайн түршилтэд заавал хамруулах бөгөөд хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид УХБ-ын зөвшөөрөл олгох улсын комиссын бүрэлдэхүүнд багтдаг. УХЭШХ-нд УХБ-ын найрлага, үйлчлэх бодисын агууламжийг шинжлэх лаборатори бий боловч тоног төхөөрөмж дутагдалтай, ажиллах боловсон хүчин нь бүрэн бэлтгэгдээгүйн улмаас одоогоор ажиллаж эхлээгүй байна.

УГТХ-ийн биотехнологийн лабораторид ин-витро орчинд таримал ургамлын вирусгүй үржүүлгийн материал бэлтгэх, ялангуяа төмсний вирусгүй булцуу үржүүлэх ажил хийгддэг бөгөөд тус хүрээлэн үүнээс өөр ургамал хамгааллын чиглэлийн судалгаа, сургалт сурталчилгаа хийдэггүй.

Хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилтэд тавих хяналт

УХБ-ын зах зээл харьцангуй жижиг бөгөөд төрийн хяналт, зохицуулалт харьцангуй сайтай. Ургамал хамгааллын хяналт, зохицуулалтыг хариуцсан төрийн ба мэргэжлийн байгууллагуудад ХХААХҮЯ, БОАЖЯ, ЭМЯ, МХЕГ болон ХААИС-ийн харъяа УХЭШХ багтана. Монгол улсад импортлох ургамал хамгааллын бодисын нэр төрөл, хэмжээг 2006 оноос дээрх гурван яамдын сайд нарын



хамтарсан тушаалаар баталж, зөвшөөрөл олгож байна. Уг тушаалыг мэргэжлийн байгууллагаас тогтоосон тухайн жилийн УХБ-ын эрэлт хэрэгцээнд үндэслэн гаргадаг.

Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд Монголд зөвшөөрөгдөөгүй УХБ-ыг шинээр оруулж ирэхдээ тухайн бүтээгдэхүүний холбогдох бичиг баримтуудыг бүрдүүлэн МХЕГ-т хүргүүлж, албан ёсны хүсэлт гарган дээжийг хилээр нэвтрүүлэн авчирч УХЭШХ-д өгч түршилтад оруулдаг. УХЭШХ-ийн судлаачид уг бүтээгдэхүүн Монгол орны уур амьсгалд хэрхэн үйлчилж байгааг 2 жил талбайн түршилтаар судалж, дүгнэлт боловсруулдаг. Энэхүү дүгнэлтэд тулгуурлан жагсаалтад оруулах, хилээр нэвтрүүлэх шийдвэрийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гаргана. Шинэ бүтээгдэхүүнийг түрших, бүртгүүлэхтэй холбогдон гарах бүх зардлуудыг импортлогч аж ахуйн нэгж хариуцна.

МХЕГ-аас агрохимийн бодисын худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд тогтмол хяналт шалгалт хийдэг. Ялангуяа химийн бодисуудыг хадгалж буй агуулахын байгууламжуудын стандарт шаардлагад нийцэж буй эсэхэд анхаардаг. Тухайн химийн бодистой ажилладаг аж ахуйн нэгж холбогдох стандарт шаардлагуудыг хангаснаар ХХААХҮЯ-наас үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авдаг. Түүнчлэн тухайн бодисыг хилээр нэвтрүүлэх үед дээж авч шинжилж, бүтээгдэхүүний тодорхойлолттой нийцэж буй эсэхийг нягтална. Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд худалдаалсан бүтээгдэхүүнийхээ мэдээллийг баримтжуулж, оны эцэст МХЕГ-т хүргүүлдэг. Харин хэрэглэсэн УХБ-ын савыг устгах нь хяналтын ажлын нэг хэсэг боловч хэрэгжихгүй, тариаланчид хоосорсон савыг зүй зохистой устгах талаар түршлагагүй байна.

Ургамал хамгааллын цогц арга хэмжээ ба Газар тариалангийн зохистой дадал

Тогтвортой хөдөө аж ахуйн нэг үндсэн тулгуур болох ургамал хамгааллын цогц арга хэмжээ (УХЦАХ)-ний зорилго нь ургамал хамгаалалд биологи, селекци, технологийн бүхий л аргуудыг цогцоор нь ашиглах замаар химийн бодисын хэрэглээг аль болох бууруулах¹ явдал юм. Эрүүл, чанартай, арвин ургацыг аль болох хямд өртгөөр үйлдвэрлэхийн тулд ургамал хамгааллын арга хэмжээг авдаг билээ. Өнөө үед дэлхий нийтээр анхаарч буй газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэл хэмээх ойлголтод аль болох химийн гаралтай ургамал хамгааллыг багасгаж², байгаль орчин, хэрэглэгчийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөөгүй үйлдвэрлэлийг ойлгоно.

Ургамал хамгааллын цогц арга хэмжээнд дараахь зарчмуудыг багтаана:

- Урьдчилан сэргийлэх: ээлжлэн тариалалт, хөрс боловсруулалт, бордоо, үсалгаа;
- “Хохирлын босго” тогтоох, ажиглалт үнэлгээ хийх: хохирлын босго нь тухайн хортон шавж, өвчин үүсгэгч буюу хог ургамлын тархалт ямар төвшинд хүрэхэд түүнтэй тэмцэх нь эдийн засгийн хувьд үр ашигтай байхыг илэрхийлдэг;
- Ургамал хамгааллын биологи, физик, химийн аргуудыг цогцоор нь хэрэглэх;
- Эрсдэл бууруулах: Гадаргын ба гүний усыг бохирдлоос хамгаалах, хөдөлмөр хамгаалал;
- Зөвхөн шаардлагатай хэмжээгээр хязгаарлах;
- Хортон шавьж, өвчин үүсгэгч, хог ургамлуудад тэсвэрлэх чадвар бий болохоос сэргийлэх;
- Ургамал хамгааллын бүх арга хэмжээг баримтжуулах зэрэг болно.

Эдгээр зарчмуудыг Европын Холбооны гишүүн орнуудын “Ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээний үндэсний хөтөлбөр”-үүдэд тусгасан байдаг. Энэхүү хөтөлбөрүүдийн гол зорилго нь УХБ-ын хэрэглээнээс үүсэх эрсдлийг бууруулахад оршино.

¹Агрохимийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо: Ургамал хамгааллын цогц арга хэмжээ; 2010.11 сар;

²Холбооны хүнс, хөдөө аж ахуйн яам: Ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээний Үндэсний хөтөлбөр; 2017.06 сар.



УХЦАХ нь газар тариалангийн зохистой дадалд зүй ёсоор тооцогдоно. “Газар тариалангийн зохистой дадал” гэдэг ухагдахуун нь газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаа мэргэжлийн зохих төвшинд нийцсэн бөгөөд мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байхыг илэрхийлдэг.

УХЦАХ-ний үндсэн зарчмуудыг олон улс орнууд ургамал хамгааллын тухай хуульдаа тусгасан байдаг. Хуульд юун түрүүнд газар тариаланд зөвхөн тухайн цаг үедээ зөвшөөрөгдсөн УХБ-уудыг ашиглах, мөн газар тариалан эрхлэгч УХБ-ыг зохистой хэрэглээний талаар сургалтад хамрагдаж тодорхой мэдлэг, чадвар эзэмшсэн бөгөөд ургамал хамгааллын бүхий л арга хэмжээгээ баримтжуулах шаардлагатайг зааж өгсөн байдаг³.

Герман улсын Ургамал хамгааллын алба газар зүйн төрөл бүрийн бүс бүслүүрт байрлах фермерийн аж ахуйнуудыг сайн дурын үндсэн дээр сонгож, УХЦАХ-ний үзүүлэнгийн буюу загвар аж ахуйн зарчмаар ажиллуулдаг. Уг аж ахуйнуудад ургамал хамгаалалд шинээр нэвтэрч буй арга хэрэгслүүдийг үйлдвэрлэлийн нөхцөлд туршиж, бусад фермерүүд, орон нутгийн ХАА-н мэргэжилтэн, зөвлөхүүд болон олон нийтэд үзүүлэн таниулдаг. Ургамал хамгааллын албаны мэргэжилтнүүд загвар аж ахуйнуудыг УХЦАХ-г хэрэгжүүлэх бүх үе шатанд нь мэдээлэл, зөвлөмжөөр ханган, дэмжиж ажилладаг⁴.

Ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ

Монгол улсын ХАА-н албан боловсролын тогтолцоо нь ХААИС-ийн бакалавр, магистр, докторын төвшний сургалт ба МСҮТ-үүд дэх ХАА-н мэргэжлийн сургалтаас бүрдэнэ. ХААИС болон МСҮТ-ийн сургалтын хөтөлбөрүүд онолын мэдлэг олгох танхимын сургалтад түлхүү анхаарч, практикийн үр чадвар олгох үйлдвэрлэлийн сургалтад харьцангуй бага цаг ногдуулдаг сул талтай. Герман улсад байдаг үйлдвэрлэлийн дадлага зонхилсон ХАА-н боловсролын тогтолцоо Монголд хараахан нэвтрээгүй байна.

Аймгийн ХХАА-н газрууд болон сумдын агрономчид тариаланчдад мэргэжлийн зөвлөгөө өгөх үүрэгтэй боловч ажлынх нь ихэнх цаг захиргааны ажилд зарцуулагдаж, хүн хүч, хөрөнгө санхүүгийн дутагдлаас шалтгаалан тэр бүр тариаланчдад хүрч ажиллах боломж бага байна. Газар тариалангийн зөвлөх үйлчилгээг түүнчлэн салбарын мэргэжлийн холбоод, ЭШ хүрээлэнгүүд, олон улсын төсөл, хөтөлбөрүүд, ТББ-ууд тодорхой хүрээнд үзүүлдэг. УХЭШХ өөрийн чиг үүргийн дагуу аймаг, орон нутгийн төрийн байгууллагын болон хувийн хэвшлийн агрономчдыг мэргэшүүлэн сургах, дадлагажуулах, зөвлөх үйл ажиллагааг эрхэлдэг. Гэвч эдгээр зөвлөх үйлчилгээ нь тогтмолжоогүй бөгөөд нийт тариаланчдыг хамруулж чаддаггүй тул үндсэндээ Монгол улсад газар тариалангийн зөвлөх үйлчилгээний тогтолцоо дутагдалтай гэж дүгнэж байна.

“Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн хүрээнд зохион байгуулсан олон удаагийн сургалт, семинар, талбайн өдөрлөг, хурал, зөвлөгөөний үеэр болон хөдөө, орон нутагт ААН-үүдийн төлөөлөл, тариаланчидтай ярилцаж, санал солилцох явцад ургамал хамгааллын сэдвээр мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг олноор зохион байгуулах хэрэгцээ шаардлага байгааг дурдаж байлаа. Үр тарианы томоохон аж ахуйнуудад ургамал хамгааллын зохих мэдлэг эзэмшсэн агрономч ажилладаг бол өрхийн жижиг тариаланчдын ихэнх нь ургамал хамгааллын мэдлэг, үр чадвар эзэмшээгүй байгаа нь анхааралд өртөж байна. Мэдлэггүйн улмаас олон тариаланчид УХБ-

³<https://www.julius-kuehn.de/pflanzenschutz/integrierter-pflanzenschutz-und-nationaler-aktionsplan/>

⁴https://www.ble.de/DE/Projektfoerderung/Foerderungen-Auftraege/Modellvorhaben/Pflanzliche-Erzeugung/Demonstrationsbetriebe-integrierter-Pflanzenschutz/demonstrationsbetriebe-integrierter-pflanzenschutz_node.html



ыг зүй бусаар хэрэглэж, байгаль орчин, хүнсний аюулгүй байдал, хүний эрүүл мэндэд эрсдэл учруулж буйг салбарын төр захиргааны болон мэргэжлийн байгууллагууд ч гэсэн хүлээн зөвшөөрч байна. ХХААХҮЯ-наас 2018 онд УХБ импортлох сонгон шалгаруулалт зарлахдаа анх удаа тухайн ААН оруулж ирсэн бүтээгдэхүүнийхээ зохистой хэрэглээний сургалтыг зохион байгуулахаар тусгасан хэдий ч импортлогч компаниудад уг сургалтыг зохион байгуулах мэдлэг, туршлага байдаг эсэх нь тодорхойгүй.

Үр тарианы болон төмс, хүнсний ногооны тариаланд ургамал хамгааллын химийн бус аргуудын хэрэглээ маш хязгаарлагдмал, үндсэндээ хог ургамалтай механик аргаар тэмцэхээс хэтрэхгүй байна.

Ургамал хамгааллын зохистой дадлыг төлөвшүүлэх чиглэлээр санал болгох бодлогын зөвлөмж

Бодлого, эрх зүйн орчин бий болгох чиглэлээр:

- “Ургамал хамгааллын цогц арга хэмжээ”-ний үндэсний хөтөлбөр боловсруулах;
- Ургамал хамгааллын тухай хуульд УХЦАХ, газар тариалангийн зохистой дадлын үндсэн зарчмуудыг тусгаж, холбогдох журмуудыг боловсруулах;
- УХБ-ын бодис импортлогчдыг сонгон шалгаруулахдаа хямд үнийн саналаас илүүтэйгээр бүтээгдэхүүний чанар, үйлчлэх бодисын үзүүлэлтийг үндсэн шалгуур болгох;

Хяналтын чиглэлээр:

- УХБ-ын импорт, тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтаас гадна хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах;
- МХЕГ, УХЭШХ зэрэг хяналт, судалгааны байгууллагууд дахь УХБ-ын ба ургамал дахь үлдэгдэлийн шинжилгээ хийх лабораториудын тоноглолыг сайжруулж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэх;

Тариаланчдын мэдлэг, үр чадварыг сайжруулах чиглэлээр:

- Ургамал хамгааллын мэдлэг, үр чадвар олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулах (“Тогтвортой хөдөө аж ахуй” төслөөс уг чиглэлээр ХХААХҮЯ, сургалтын байгууллагууд ба ХАА-н техникийн диллер компаниудын хамтран ажиллах концепци боловсруулж байна);
- Мэргэжлийн холбоод, мэргэшсэн ТББ-уудаас ургамал хамгааллын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх (Тухайлбал Тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн холбоо ТББ хөдөлмөр хамгааллын аюулгүй байдал сэдвээр сургалт, зөвлөгөө өгч байна);
- Ургамал хамгааллын цогц арга хэмжээ, газар тариалангийн зохистой дадлыг эзэмшиж, үйлдвэрлэлд нэвтрүүлж буй аж ахуйнуудыг загвар аж ахуйгаар тодруулж, тэдний сайн туршлагаас бусад тариаланчид, орон нутгийн агрономчид суралцах боломжоор хангах;
- УХБ-той зохистой харьцах, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, хэрэглэсэн УХБ-ын сав, баглаа боодлыг устгах зэрэг сэдвүүдээр олон нийтэд хандсан мэдээлэл, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх зэрэг болно.

Эх сурвалжууд:

- (1) *Агротехникийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо: Ургамал хамгааллын цогц арга хэмжээ; 2010.11 сар;*
- (2) *Холбооны хүнс, хөдөө аж ахуйн яам: Ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээний Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр; 2017.06 сар;*
- (3) *Юлиус Кюн хүрээлэн: Ургамал хамгааллын цогц арга хэмжээ болон Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр(<https://www.julius-kuehn.de/pflanzenschutz/integrierter-pflanzenschutz-und-nationaler-aktionsplan/>);*
- (4) *Холбооны хүнс, хөдөө аж ахуйн газар: “Ургамал хамгааллын зохистой дадлыг турших, үзүүлэх загвар аж ахуйн нэгжүүд” төсөл (https://www.ble.de/DE/Projektfoerderung/Foerderungen-Auftraege/Modellvorhaben/Pflanzliche-Erzeugung/Demonstrationsbetriebe-integrierter-Pflanzenschutz/demonstrationsbetriebe-integrierter-pflanzenschutz_node.html).*



“Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг зөвлөх үйлчилгээний IAK Agrar Consulting, AFC Consulting International, DLG International компаниуд, ХАА-н сургалтын DEULA Nienburg төвийн хамтарсан консорциум хэрэгжүүлдэг. Уг консорциумыг тэргүүлэгч IAK Agrar Consulting ХХК нь ХАА-н хараат бус, мэргэшсэн зөвлөх үйлчилгээг төрийн байгууллагууд, 180 гаруй ААН-үүдэд үзүүлж, төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. IAK Agrar Consulting ХХК-ийн Герман болон гадаад улс орнууд дахь үндсэн үйл ажиллагаа болох ХАА-н зөвлөх үйлчилгээ нь төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд, хувийн хэвшлийн ААН-үүд, нийгэмлэг, холбоод болон олон улсын байгууллагуудад хамруулдаг. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хөдөөгийн ба хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил, ХАА-н боловсролыг дэмжих чиглэлээр ХБНГУ-ын ХХААЯ, ГОУХАН, Европын Холбоо, Дэлхийн банк зэрэг донор байгууллагуудын санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Вэбсайт: www.iakleipzig.de

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогчид хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.